



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 764.

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 67 дугаар зүйлийн 67.5, "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 47 дугаар зүйлийн 47.1.4, аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/253 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төв аймаг байгуулагдсны түүхт 100 жилийн ойн бүтээн байгуулалт, аймгийн Засаг даргаар батлуулсан байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын авто зогсоол, талбайн газар шороо, бетон тэгшилгээний ажилд шаардагдах 19 560 000 (Арван есөн сая таван зуун жаран мянган) төгрөгийн зардлыг баталсугай.

2.Төсвийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Бадамханд)-д зөшөөрсүгэй.

3.Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах ажлыг Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Болормаа)-д, чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлэн хяналт тавьж, хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга (Д.Алтансүх)-д даалгасугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Ц.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.НАСАНЖАРГАЛ

41230100